



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

УЛСЫН ИХ ХУРЛААС БАТЛАГДСАН МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТ

Боловсруулсан: П.Хишигбаяр

Хянан тохиолдуулсан: Д.Оюунбадам (PhD)

2016 оны 12-р сар

Энэхүү тойм дүгнэлт нь Нээлттэй Нийгмийн Форумын албан ёсны байр суурь биш бөгөөд зөвхөн хувь судлаачийн байр суурийг илтгэнэ.

АГУУЛГА

ХУРААНГУЙ	4
НЭГ. УИХ-ААС БАТЛАГДСАН МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ	5
ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ: БАТЛАГДСАН ТӨСӨВ БОЛОН ӨРГӨН БАРЬСАН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ ШИНЖИЛГЭЭ	7
ГУРАВ. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	12
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	13

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	–	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	–	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ГҮЙЦ	–	Гүйцэтгэл (Төсөв)
ДНБ	–	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	–	Засгийн газар
НДШ	–	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	–	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ННФ	–	Нээлттэй нийгэм форум
ОУВС	–	Олон улсын валютын сан
ТГБТХ	–	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТОД	–	Тодотгосон төсөв
ХХОАТ	–	Хувь хүний орлогын албан татвар
УИХ	–	Улсын Их Хурал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого (2005 – 2017 он)	5
Зураг 2 УИХ-аас батлагдсан 2017 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөлт, УИХ-д өргөн барьсан төсвийн төслийн харьцуулалт	7
Зураг 3 Батлагдсан төсвийн орлогын төрөл тус бүрээр харьцуулсан үзүүлэлт	8
Зураг 4 УИХ-д өргөн барьсан 2013 – 2017 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн орлогын харьцуулалт	10

ХУРААНГУЙ

Тус тойм дүгнэлт судалгаа нь өмнөх боловсруулж байсан тойм дүгнэлтүүдээс онцлог ялгаатай. Учир нь 2014, 2015, 2016, 2017¹ оны нэгдсэн төсвийн тойм дүгнэлтүүд нь зөвхөн Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн төслүүдэд хийж байсан бол энэхүү тойм дүгнэлт нь анх удаа УИХ-аас батлагдсан нэгдсэн төсөвт хийж буйгаараа онцлог юм. Өргөн барьсан төсвийн төсөлд тойм дүгнэлт шинжилгээ хийх нь бодлого боловсруулагчид болон хэвлэл мэдээллийнхэн, иргэд, олон нийтэд төсвийн талаар хараат бус, тоон мэдээлэл судалгаанд суурилсан мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой. Мөн тойм дүгнэлтээс гарсан зөвлөмжийг төсөв батлах үйл явцад анхааран тусгах боломжийг бий болгодог. Харин батлагдсан төсвийн хувьд тойм дүгнэлт боловсруулах нь Сангийн яам болон харьяа мэргэжлийн байгууллагуудаас оруулсан төсвийн саналыг УИХ-ын гишүүд, намын бүлгүүдийн зүгээс хэрхэн өөрчлөж буйг бодитоор харуулах, төсвийн орлогод үүсч болзошгүй эрсдэлд улс төрийн хүчин зүйлс нөлөөлж буй эсэхийг илрүүлэх боломж олгох юм.

Энэхүү тайлангийн үндсэн зорилго нь УИХ-аас баталсан Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсөв, бусад дагалдах хуулиудад орлого төлөвлөлтийн талаас тойм дүгнэлт хийж, төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр бодлогын зөвлөмж боловсруулах, төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий хэлбэрээр танилцуулахад оршино.

Боловсруулсан тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтсан. Үүнд:

- УИХ-аас батлагдсан Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Батлагдсан төсөв болон Өргөн барьсан төслийн харьцуулалт шинжилгээ
- Бодлогын зөвлөмж

Тойм дүгнэлтийг боловсруулахдаа 2013 – 2016 оны хооронд ННФ-аас хийсэн Төсвийн тойм дүгнэлтүүд, Сангийн яамны төсвийн мэдээллүүд, Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банк, бусад олон улсын судалгааны байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлан боловсруулав.


¹ 2017 оны Нэгдсэн төсвийн орлогын төсөлд тойм дүгнэлт хийсэн болно.

НЭГ. УИХ-аас БАТАЛСАН МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

УИХ-ын зүгээс Монгол Улсын 2017 оны Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 6.39 их наяд төгрөг буюу 2016 оны тодотголтой (цаашид Тод) харьцуулахад 19%-иар буюу 1.04 их наяд төгрөгөөр өсөхөөр, 2017 оны УИХ-д өргөн барьсан төсөлтэй (цаашид төсөл) харьцуулахад 3.1%-иар буюу 0.19 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

Нэрлэсэн ДНБ-ийг 26.49 их наяд төгрөгт хүрч 2016 оны тодотголоос 9.5%-иар буюу 2.23 их наяд төгрөгөөр өсөхөөр тооцон баталсан бол УИХ-д өргөн барьсан төслөөс 1.2%-иар буюу 0.31 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж баталсан. Нэгдсэн төсвийн нийт орлогыг нэрлэсэн ДНБ-тай харьцуулахад 23.3% байхаар тооцон баталсан.

Зураг 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого (2005 – 2017 он)



Төсвийн тогтворжуулалтын санд 8.39 тэрбум төгрөг хуримтлуулахаар төлөвлөсөн буюу 2016 оны төсвөөс 0.6%-иар, УИХ-д өргөн барьсан 2017 оны төслөөс 32.8%-иар буюу 4.09 тэрбум төгрөгөөр бууруулан тус тус баталсан. 2017 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхлэх Ирээдүйн өв санд 221.65 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд энэ нь УИХ-д өргөн барьсан 2017 оны төслөөс 6.5%-иар буюу 13.53 их тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн нийт орлогын 78% буюу 4.98 их наяд төгрөгийг татварын орлогоос, 18.4% буюу 1.17 их наяд төгрөгийг татварын бус орлогоос, 3.6% буюу 0.23 их


наяд төгрөгийг тогтворжуулалтын сан болон ирээдүйн өв сангийн орлогоос тус тус бүрдүүлэхээр тооцон баталсан байна.

ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ: БАТЛАГДСАН ТӨСӨВ БОЛОН ӨРГӨН БАРЬСАН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ ШИНЖИЛГЭЭ

УИХ-аас баталсан 2017 оны нэгдсэн төсвийн орлогын хэмжээг өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад төсвийн нийт орлогыг 195 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, төсвийн орлогыг зарлагатай нийцүүлэн өсгөж төсөөлдөг ноцтой алдааг давтан, төсвийн орлого тасалдах эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

УИХ-аас баталсан 2017 оны нэгдсэн төсвийн орлогын хэмжээг өргөн барьсан төсвийн төсөлтэй татварын голлох орлогын төрөл бүрээр харьцуулахад татварын орлогыг 78 тэрбумаар, татварын бус орлогыг 46 тэрбумаар, хөрөнгийн орлогыг 50 тэрбумаар, тусламжийн орлогыг 11 тэрбумаар тус тус нэмэгдүүлж, төсвийн нийт орлогыг 195 тэрбум төгрөгөөр өсгөж 2017 оны төсвийн орлогын эрсдэлийг нэмэгдүүлсэн байна. Мөн нэгдсэн төсвийн үр дүнгийн харьцааг илэрхийлэх чухал хэмжигдэхүүн болох нэрлэсэн ДНБ-ий хэмжээг өргөн барьсан төслөөс 310 тэрбум төгрөгөөр өсгөж 26.49 их наяд болгож баталсан нь 2017 оны төсвийн орлогыг ихээхэн өөдрөг байдлаар тооцсон болох нь харагдаж байна (Зураг 2).

Зураг 2. УИХ-аас баталсан 2017 оны Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөлт, УИХ-д өргөн барьсан төсвийн төслийн харьцуулалт



Өөдрөг төсөөллөөр төсвийг баталсан гол шалтгаан нь төсвийн орлогыг төсвийн зарлагад нийцүүлэн, төсвийн үр дүнгийн үзүүлэлт болох төсвийн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлдэг өмнөх жилүүдийн төсөвт ажиглагддаг алдаатай жишгийг дагасан байна гэж судлаачийн зүгээс үзэж байна. Учир нь 2017 оны нэгдсэн төсвийн төслийг УИХ-д өргөн барьснаас хойш Монгол Улсын эдийн засагт ямар нэгэн хэмжээгээр эдийн засаг сэргэх

шинж тэмдэг, бодлогын өөрчлөлт гараагүй. Харин бодит эдийн засагт сүүлийн сард ам.доллартай харьцах төгрөгийн ханш огцом хэлбэлзэж, олон улсын үнэлгээний байгууллагууд болох “Moody’s”, “Fitch”-ийн зүгээс Монгол Улсын болон томоохон арилжааны банкуудын зээлжих зэрэглэлийг бууруулсан зэрэгтэй уялдуулан дүгнэхэд төсвийн нийт орлогыг 195 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн батлах бодит үндэслэл сул байгааг харуулж байна.

УИХ-аас баталсан 2017 оны нэгдсэн төсвийн орлогыг нарийвчлан судлах зорилгоор татварын төрөл тус бүрийн 2016 оны төсвийн тодотгол, УИХ-д өргөн барьсан төсөлтэй абсолют болон өсөлтийн хувь хэмжээг харьцуулан доорх зурагт дэлгэрэнгүй харуулав (Зураг 3).

2016 оны тодотголтой харьцуулахад орлогын албан татварын орлого 104 тэрбум төгрөгөөр, НӨАТ-ын орлого 157 тэрбум төгрөгөөр, гаалийн албан татвар 94 тэрбум төгрөгөөр тус тус өсөхөөр баталсан. Эдгээр татварын орлогын төрлүүд нь эдийн засгийн өсөлт, аж ахуй нэгжүүдийн борлуулалтын өсөлттэй шууд хамааралтай юм. Өөрөөр хэлбэл, 2017 онд эдийн засгийн өсөлт 2016 онтой харьцуулахад 10%, түүнээс дээш хувиар өсч байж дээрх дурдсан дүнгээр орлогын албан татварыг төвлөрүүлэх боломжтой юм. Гэвч Дэлхийн банк, ОУВС, Азийн Хөгжлийн Банк, Монголбанкнаас гаргасан Монгол Улсын ирэх оны эдийн засгийн өсөлтийн төсөөллөөс үзэхэд эдийн засаг 10%, түүнээс дээш хувиар өсөх бололцоо байхгүй байна.

Зураг 3. Батлагдсан төсвийн орлогын төрөл тус бүрээр харьцуулсан үзүүлэлт

(Тэрбум Төгрөг)	2016 Тод	Δ2017Бат/(2016 Тод)	Δ2017Бат/(2016 Тод)%	2017 Төс	Δ2017Бат/(2017 Төс)	Δ2017Бат/(2017 Төс)%	2017 Бат
Татварын орлого	4,511	+473	+10%	4,906	+78	+2%	4,984
Орлогын албан татвар	952	+104	+11%	1,055	+1	+0%	1,056
ХХОАТ	518	+89	+17%	555	+53	+9%	608
ААНОАТ	434	+62	+14%	500	-4	-1%	495
НДШ хураамж	1,055	+119	+11%	1,163	+11	+1%	1,174
Хөрөнгийн татвар	56	+8	+14%	64	+0	+0%	64
НӨАТ	1,081	+157	+14%	1,238			1,238
НӨАТ-ын буцаан олголт	(102)	-68	-67%	(170)			(170)
Онцгой албан татвар	532	+15	+3%	547	-0	+0%	547
Тусгай зориулалтын орлого	42	+2	+5%	44	-0	-0%	44
Гаалийн албан татвар	302	+94	+31%	380	+16	+4%	396
Бусад татвар (төлбөр, хураамж)	489	-61	-12%	414	+14	+3%	428
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	255	-133	-52%	108	+14	+13%	123
Ө.НАМ нөөц ашигласны төлбөр	-			-			-
Нийслэл хотын албан татвар	10	+10	+100%	20			20
Татварын бус орлого	838	+339	+40%	1,069	+107	+10%	1,176
Хувьцааны ногдол ашиг	12	+8	+95%	11	+10	+95%	21
Өмч хувьчлалын орлого	1	+176	+39%	127	+50	+39%	177
Тусламжийн орлого	112	+33	+30%	135	+11	+8%	145

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам

Татварын бус орлогыг 2016 оны тодотголтой харьцуулахад 339 тэрбум төгрөгөөр, өмч хувьчлалын орлогыг 176 тэрбум төгрөгөөр, тусламжийн орлогыг 33 тэрбум төгрөгөөр тус тус өсөхөөр баталсан байна. Өөрөөр хэлбэл, УИХ-аас баталсан 2017 оны төсвийн орлого нь 2016 оны төсвийн тодотголтой харьцуулахад татварын болон татварын бус орлого үлэмж хэмжээгээр нэмэгдэж

2017 онд Монгол Улсын эдийн засаг хурдтай өсөх хэт өөдрөг (эсхүл тооцоогүй) таамаглалд үндэслэн боловсруулагдсан байна. Эндээс үзэхэд Монгол Улсын эдийн засгийн бодит нөхцөл байдлыг УИХ-ын гишүүд буюу шийдвэр гаргагчдын зүгээс бүрэн ойлгохгүй эсхүл ойлгохыг хүсэхгүй, Засгийн газар/Сангийн яам буюу төсөл боловсруулагчид нөхцөл байдлыг улс төрчдөд ойлгуулж чадахгүй эсхүл мэргэжлийн бус байгааг нотлон харуулж байна.

УИХ-д өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулан харахад ХХОАТ, НДШ-ийн хураамжийн татварын орлогыг 53 болон 11 тэрбум төгрөгөөр тус бүр нэмэгдүүлэн баталсан байна. 2017 оны 1-р сарын 1-нээс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 240 мянган төгрөг байхаар шинэчлэн баталсан. Тус өөрчлөлтөөр ХХОАТ, НДШ-ийн хураамжийн орлого нэмэгдэх боломжтой боловч нэмэгдэх орлогын дүнг УИХ-д өргөн барьсан төсвийн төсөлд тооцсон байсан гэж үзвэл 2017 онд ХХОАТ, НДШ-ийн хураамжийн орлогыг 64 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үндэслэл мөн сул байгааг харуулж байна. Татварын бус орлогын хувьд өмч хувьчлалын орлогыг УИХ-д өргөн баригдсан төсөлтэй харьцуулахад 50 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 177 тэрбум төгрөг төвлөрөх боломжтой гэж үзсэн байна. Төрийн өмч хувьчлалыг нээлттэй дуудлага худалдааны зарчмыг ашиглан явуулсан нөхцөлд өмнөх орлого төвлөрөх боломжтой ч эдийн засгийн нөхцөл байдал улам бүр хүндэрч байгааг сайтар тооцох хэрэгтэй.

Сүүлийн 5 жилд засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн төсөл болон УИХ-аас батлагдсан төсвийн орлогын хэмжээг татварын төрөл бүрээр харьцуулан доорх хүснэгтээр харуулав. Зарим эдийн засагчдын үзэж буйгаар Сангийн яамны зүгээс харьцангуй тооцоо судалгаатай төсвийн төслийг УИХ-д өргөн барьж, мэдүүлдэг хэдий боловч УИХ-ын гишүүд, улс төрчдийн зүгээс төсвийн зарлагыг нэмж, зарлагын өсөлтөд нийцүүлж орлогыг нэмэгдүүлэн төсвийн төсөлд ихээхэн хэмжээний өөрчлөлт оруулдаг гэж үздэг.

Зураг 4. УИХ-д өргөн барьсан 2013 – 2017 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн орлогын харьцуулалт

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРГӨН БАРЬСАН ТӨСӨЛ БОЛОН УИХ-аас БАТЛАГДСАН ОРЛОГЫН ЗӨРҮҮ:						
	2013	2014	2015	2016	2017	
Орлогын албан татвар	-	-	-	-	1.2	
ХХОАТ	-	-	-	-	5.6	
ААНОАТ	-	-	-	-	(4.3)	
НДШ, хураамж	-	-	-	12.0	11.1	
Хөрөнгийн татвар	-	-	-	-	-	
НӨАТ	(2.6)	(267.4)	(295.3)	(392.6)	156.6	
Онцгой албан татвар	-	-	-	-	-	
Тусгай зориулалтын орлого	-	-	-	-	(0.0)	
Гаалийн албан татвар	-	-	-	-	15.8	
Бусад татвар (төлбөр, хураамж)	-	-	-	-	14.1	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	457.7	-	-	14.3	
Ө.НАМ нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Нийслэл хотын албан татвар	-	-	-	-	-	
Татварын бус орлого	(10.1)	(6.6)	63.5	389.6	107.2	
Хувьцааны ногдол ашиг	3.8	-	-	-	10.0	
Өмч хувьчлалын орлого	-	-	-	-	50.0	
Тусламжийн орлого	-	-	-	-	10.8	

Бодитой бус үндэслэлээр нэмэгдүүлсэн байж болзошгүй орлого

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам.

УИХ-д өргөн барьсан 2013 – 2016 оны төсвийн төсөл болон УИХ-аас батлагдсан төсвийг харьцуулан харахад татварын орлогод төдийлөн өөрчлөлт оруулдаггүй харин татварын бус болон уул уурхайн салбарын орлогоос үлэмж хэмжээний орлого төвлөрнө гэж төсвийн төсөлд өөрчлөлт оруулах хандлага түгээмэл байсан байна (Зураг 4). Тухайлбал, 2014 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 457.7 тэрбум төгрөг төвлөрөх, 2015-2016 онд татварын бус орлого 63 болон 389 тэрбум төгрөгөөр нэмэгдэх зэргээр өөрчлөн баталж байжээ. Үр дүнд нь сүүлийн 5 жилд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого жил бүр дунджаар 1.1 их наяд төгрөгөөр тасарсан².

2017 оны хувьд өмнөх жилүүдтэй харьцуулахад нэгдсэн төсвийн төслийг хамгийн ихээр засаж, төсвийн эрсдэлийг нэмэгдүүлсэн байна. Өмнөх жилүүдэд Засгийн Газраас өргөн барьсан төсвийн төслийн 2 – 3 төрлийн татварын болон татварын бус орлогын хэмжээнд УИХ-аас өөрчлөлт оруулан баталдаг байсан бол 2017 онд хөрөнгийн татвар, онцгой албан татвараас бусад бүх татварын төрлийг өөрчлөн (нэмэгдүүлэн) баталсан байна. Төсвийн бодлогоор дамжуулан төсвийн орлого бүрдүүлэх, орлого тасалдлыг зогсоох, өрийн дарамтыг бууруулах, төсвийн алдагдлыг бууруулах зэрэг сахилга баттай арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Гэвч УИХ, шийдвэр гаргагчдын хувьд татварын орлого бүрийг зарлагатай нийцүүлэн өсгөж батлахад түлхүү анхаарал хандуулж төсвийн бодлогын зарчмыг сахих, төсвийн сахилга батыг

² Дэлгэрэнгүйг “Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн орлогын төсөлд хийсэн тойм дүгнэлт” илтгэлээс үзнэ үү.

(http://forum.mn/res_mat/2016/Forum_2017-Revenue%20Analysis_ppt_2016.11-FINAL.pdf)

дээшлүүлэхэд төдийлөн анхаарал хандуулахгүй байгаа нь цаашид төсвийн эрсдэл, улсын эрсдэл нэмэгдэх суурь хүчин зүйлс болж байна.

Өнөөгийн нөхцөл байдалд ОУВС –ийн хөтөлбөрт хамрагдах, БНХАУ-аас хөнгөлөлттэй зээл хүсэх зэрэг нь эдийн засгийн хүндрэлээс гарах, төлбөрийн эрсдэлийг саармагжуулах, эдийн засгийг идэвхжүүлэх, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах боломжит арга хувилбарууд мөн боловч төсвийн сахилга бат хангалтгүй, төсвийн алдагдал ихтэй одоогийн бодлогыг үргэлжлүүлэн явуулсаар байвал цоорхой саванд ус хадгалахтай адил юм.

ГУРАВ. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

УИХ-аас баталсан 2017 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого төлөвлөлтийг боловсруулахад ашигласан суурь зарчмуудын ихэнх нь эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй өнөө үед хэрэгжих боломж бага, 2017 онд нэгдсэн төсвийн орлогод тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй.

Тойм судалгааны дүгнэлтийг харгалзан дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна:

- УИХ-д өргөн барьсан болон батлагдсан төсвийн харьцуулалтаас дүгнэхэд татварын орлогыг үндэслэлгүйгээр нэмж тооцох нь 2017 оны төсөвт ихээр ажиглагдаж байна. Иймээс хараат бусаар төсөв боловсруулах, төлөвлөх, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгох бодит шаардлага урган гарч байна;
- Төсвийн бодлогоор дамжуулан төсвийн орлого бүрдүүлэх, орлогын тасалдлыг зогсоох, өрийн дарамтыг бууруулах, төсвийн алдагдлыг бууруулах зэрэг сахилга баттай арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх;
- Засгийн газар/Сангийн яамнаас УИХ-д өргөн барьсан төсвийн төсөл болон УИХ-аас батлагдсан нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг иргэд олон нийт, олон улсын байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд хянах, улирал бүр төсвийн гүйцэтгэлийн талаар нээлттэй сонголт явуулах;
- 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан төсвийн орлогыг бодитой төлөвлөх;
- Олон улсын болон гадаад тусламжид найдахаас илүүтэйгээр сахилга батыг төсөвт мөрдөх
- Төсвийн орлогын төрөлжилтийг нэмэгдүүлэх дунд, урт хугацааны бодлогод анхаарах, нэгдсэн төсвийн орлогын бүтцийг сайжруулах;
- Төсвийн орлогыг төсвийн зарлагад нийцүүлэн, төсвийн үр дүнгийн үзүүлэлт болох төсвийн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлдэг алдаатай жишгийг халах эрхзүйн тогтолцоо бүрдүүлэх;
- Монгол Улсын төсвийн орлогын гол суурь болсон аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүг бэхжүүлэх, татвараар дэмжих төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;
- Өмч хувьчлалыг нээлттэй дуудлага худалдааны зарчмыг ашиглан явуулсан нөхцөлд төлөвлөсөн орлого төвлөрөх боломжтой ч эдийн засгийн нөхцөл байдал улам бүр хүндэрч байгааг сайтар тооцох;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын 2017 оны төсвийн төслийн баримт бичгүүд (төсвийн хуулийн төслүүд, төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга), баталсан төсвийн баримт бичиг
2. “Нээлттэй Нийгэм Форум” 2013 – 2017 оны Хараат бус Төсвийн тойм дүгнэлт материалууд
3. 2005-2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, холбогдох тайлангууд, Төсвийн тухай хууль
4. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
5. Монголбанк, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл
6. Үндэсний Аудитын Газар, Монгол улсын 2017 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт